



АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ **TÖHK** Ш. БАЯНМОНХ



ГРИЙН ХИМИСТРИ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ **B.DAVAACEREN**

**ХИМИЙН БОДИС, ШИЛ САВ ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

Дугаар № 15/2022

2022 оны 22 сарын 22 ..р сарын .. ёдөр

Улаанбаатар хот

Нэг талаас “АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ” Төрийн өмчтэй хувьцаат компани /цаашид “Захиалагч” гэх/-ийг төлөөлж Гүйцэтгэх захирал Ш.Баянмөнх нөгөө талаас Грийн химистри ХХК-ийн захирал Б.Даваацэрэн /цаашид “Нийлүүлэгч” гэх/ нар Төрийн болон Орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйл, 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тус тус үндэслэн дараах зүйлүүдийг харилцан тохиролцож энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ”гэх) байгуулав.

**Нэг. Гэрээгээр нийлүүлэх зүйл, нөхцөл**

1.1 Нийлүүлэгч нь “Химиин бодис,шил сав” (цаашид “бараа” гэх)-ыг энэхүү гэрээний салшгүй хэсэг болох нэгдүгээр хавсралтанд заасан нэр төрөл, нэг бүрийн үнэ, техникийн үзүүлэлт, стандартын дагуу Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад нийлүүлнэ.

**Хоёр. Бараа нийлүүлэх хугацаа**

2.1 Нийлүүлэгч нь барааг гэрээнд хоёр тал гарын үсэг зурж баталгаажуулснаас хойш 30 хоногийн дотор багтаан нийлүүлнэ.

**Гурав. Үнэ төлбөрийн нөхцөл**

3.1 Энэ гэрээний нийт үнэ 62,175,820 /жаран хоёр сая нэг зуун далан таван мянга найман зуун хорь/-н төгрөг бөгөөд Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад хүргэх, тээврийн зардал, НӨАТ бүгд шингэсэн байна.  
3.2 Захиалагчаас нийлүүлэгчид урьдчилгаа төлбөр төлөхгүй.  
3.3 Төлбөрийг бараа нийлүүлж дууссан гүйцэтгэлээр олгоно.  
3.4 Барааг хүлээн авсаны дараа бараа хүлээн авсан акт, гэрээ дүгнэсэн акт, нийлүүлэгчийн нэхэмжлэлийг үндэслэн 30 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн Голомт банкны 2205034984 тоот дансанд шилжүүлнэ.

**Дөрөв. Талуудын хүлээх хариуцлага**

4.1 Нийлүүлэгч нь гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, хугацаандаа нийлүүлээгүй барааны нийт үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг захиалагчид хоног тутам

- төлөх ба нийт алдангийн үнийн дүн гэрээний нийт үнийн дүнгийн 10% -иас хэтрэхгүй байна.
- 4.2 Захиалагч нь барааны бүрэн бүтэн байдал, техникийн үзүүлэлт, шаардлагад тохирч байгаа эсэхийг шалган үзээд хүлээн авсаны дараа гэрээнд заасан хугацаанд тооцоо хийх, төлбөрийн хугацааг хожимдуулбал хожимдсон хоног тутамд хүлээгдэж байгаа төлбөрийн 0.1 хувьтай тэнцэх алдангийг Нийлүүлэгчид төлөх ба алдангийн дүн нь гэрээний хүлээгдэж байгаа төлбөрийн үнийн дүнгийн 10% хувиас хэтрэхгүй байна.
- 4.3 Барааг Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад ирсний дараа тус компанийн бараа хүлээн авах комисс шаардлага хангаж байгааг тогтоосон тохиолдолд барааг хүлээн авна. Барааг шаардлага хангаагүй тохиолдолд буцаана.
- 4.4 Барааг хугацаандаа нийлүүлж чадаагүй тохиолдолд түүнээс гарах хохирлыг нийлүүлэгч тал бүрэн хариуцна.
- 4.5 Захиалагчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Амгалан амгалан дулааны станц ТӨХК-ийн Химийн инженер Д.Хишигшинэн хариуцан ажиллана. Утас-88100929
- 4.6 Нийлүүлэгчийг төлөөлж гэрээтэй холбоотой асуудлыг Грийн химистри ХХК-ийн химич О. Ариунжаргал хариуцан ажиллана. Утас-80223366

#### **Тав. Бараа бүтээгдэхүүний чанар, сав, баглаа, боодол**

- 5.1 Нийлүүлэгчийн нийлүүлэх бараа нь Олон улсын болон Монгол улсын стандарт шаардлагыг бүрэн хангасан байна.
- 5.2 Нийлүүлсэн бараанд ямар нэгэн дутагдал, шаардлагад нийцээгүй бараа илэрвэл дутагдлыг арилган, сольж өгөхийг Захиалагч шаардах ба нийлүүлэгч шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.
- 5.3 Нийлүүлэгч нь нийлүүлсэн барааг ашиглаж эхэлсэн өдрөөс хойш **12** сарын баталгаа гаргана. Нийлүүлэгчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан гэмтэл согогийг өөрийн зардлаар засаж залруулах үүрэгтэй.

#### **Зургаа. Бараа хүлээн авах**

- 6.1 Нийлүүлэгч нь ачигдсан барааг Улаанбаатар хотын Амгалан дулааны станц ТӨХК-ийн агуулахад бараа хүлээн авах комисс хүлээн авна.
- 6.2 Нийлүүлэгч нь барааг Захиалагчид хүлээлгэн өгөх хүртэлх бүх зардлыг хариуцна.

#### **Долоо. Давагдашгүй хүчин зүйл**

- 7.1 Гэрээг хэрэгжүүлэх явцад улс төрийн хориг, байгалийн гамшиг, цэргийн үймээн, төрийн эргэлт, ажил хаялт болон бусад нөхцлүүд бий болсноос үүдэж гэрээний нөхцлүүд хэсэгчилэн болон бүрэн биелээгүй тохиолдолд хоёр талын аль нь ч хариуцлага хүлээхгүй
- 7.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөхцлүүд гарч эхэлсэн тохиолдолд **5** хоногийн дотор талууд бие биедээ бичгээр мэдээлж цаашид хэрхэн ажиллах талаар зөвшилцөнө.

#### **Найм. Гэрээг цуцлах үндэслэл**

- 8.1 Нийлүүлэгч нь бараа материал нийлүүлэх энэхүү гэрээнд зааснаас 30 хоног хэтрүүлсэн тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах тухай мэдэгдлийг Нийлүүлэгчид албан ёсоор бичгээр өгнө. Нийлүүлэгч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор зохих

хариуг өгч тодорхой арга хэмжээ авахгүй тохиолдолд Захиалагч гэрээг цуцлах ба баталгааг буцаан олгохгүй.

8.2 Нийлүүлэгч энэхүү гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа буюу ноцтой зөрчсөнөөс бусад тохиолдолд Захиалагч энэхүү гэрээний үйлчлэлийг дуусахаас өмнө тасалдуулахгүй.

### Ес. Бусад нөхцөл

- 9.1 Талуудын аль нэг нь нөгөөдөө гэрээтэй холбогдох мэдээлэл солилцох тохиолдолд мэдээллийг авсан тал хуанлийн 7 хоногт багтаан нөгөө талдаа тавьсан асуудлаар тодорхой хариу өгнө.
- 9.2 Талууд аль нэгнийхээ зөвшөөрөлгүйгээр энэхүү гэрээг гурав дахь талд шилжүүлэхийг хориглоно.
- 9.3 Гэрээг монгол хэл дээр 4 хувь үйлдэж, Захиалагч 3 хувийг Нийлүүлэгч 1 хувийг авах бөгөөд хувиуд ижил тэгш хүчинтэй.
- 9.4 Гэрээг хоёр тал зөвшөөрсөн тохиолдолд сунгаж болно.
- 9.5 Гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан өдрөөс хүчин төгөлдөр байна.
- 9.6 Гэрээнд талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр бичгээр үйлдсэн гэрээний хэлбэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмж засварласан эх хувьд баллаж засварласан буюу гараар нэмж бичсэн болон бусад энгийн аргаар хийсэн оруулга засвар нэмэлт бичилтийг хүчинтэйд тооцохгүй.
- 9.7 Энэхүү гэрээнд шууд заагаагүй бусад аливаа асуудлыг Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

АМГАЛАН ДУЛААНЫ СТАНЦ ТӨХК-ИЙН

СЭЗХ-ИЙН ДАРГА БӨГӨӨД ЕРӨНХИЙ  
НЯГТЛАН БОДОГЧИЙН АЖИЛ ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭГГЭГЧ Ө.УДВАЛ  
Гарын үсэг:

ХАНГАМЖИЙН ХЭЛТСИЙН ДАРГА  
Г. ЭРДЭНЭБИЛЭГ

Гарын үсэг:

НЭГДСЭН ЦЕХИЙН ДАРГА  
Ж.АРИУНЖАРГАЛ

Гарын үсэг:

ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Г. САРУУЛ

Гарын үсэг:

ГЭРЭЭ БОЛОВСРУУЛСАН:  
ЦАХИМ ХУДАЛДАН АВАЛТ ХАРИУЦСАН

АЖИЛТАН

Г.БАЯРЧИМЭГ

Гарын үсэг:

Хаяг: Улаанбаатар хот

Баянзүрх дүүрэг, 8-р хороо, ус 15-1-1

Утасны дугаар: 77111251 РД: 6021646

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГРИЙН ХИМИСТРИ ХХК-ИЙН

ХИМИЧ О.АРИУНЖАРГАЛ

Гарын үсэг:

Хаяг: Улаанбаатар хот: Баянзүрх дүүрэг 5-р хороо  
Рерихийн гудамж Утас 88008923

РД: 5640954

тоот гэрээний хавсралт

GREEN  
CHEMISTRY  
LLCУЛААНБААТАР ХОТ  
ТТС6939-и-5540254

Химийн бодис шил сав нийлүүлэх жагсаалт

№	Бараа материалын нэрс	Гарал үүсэл	Марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Автомат пипетка	БНХАУ	10 мл	ш	2	170,280	340,560
2	Автомат Микробюретка	БНХАУ	10 мл	ш	2	451,000	902,000
3	Нэг удаагийн бээлий	БНХАУ	хайрцаг	ш	4	43,010	172,040
4	Дусаагуур	БНСҮ	100 мл	ш	5	6,050	30,250
5	Стандарт нүүрс	БНХАУ	Хятад стандарт	хайрцаг	2	273,680	547,360
6	Нихром утас	БНХАУ	0.12 мм	багц	3	55,000	165,000
7	Хүхрийн тигель	БНХАУ	77м	ш	7	8,800	61,600
8	Калориметрийн тигель	БНХАУ	φ2.0-3.0 см, өндөр-1.5см	ш	6	8,800	52,800
9	Силикагель	БНХАУ	MCM	кг	500	15,620	7,810,000
10	Усан аммиак	БНХАУ	Химийн цэвэр	л	4100	1,597	6,548,520
11	Гидро-Х	ОХУ	Химийн цэвэр	л	1450	7,172	10,399,400
12	Натрийн шүлт	БНХАУ	Химийн цэвэр	кг	500	8,800	4,400,000
13	Давсны хүчил	ОХУ	Химийн цэвэр	л	50	8,375	418,770
14	Тринатрифосфат	ОХУ	Химийн цэвэр	кг	1300	9,240	12,012,000
15	Төмрийн стандарт уусмал	ХБНГУ	Стандарт уусмал	л	0.5	645,040	322,520
16	Суурин PH метр багаж	ХБНГУ	Apera PC820 нарийвчлалтай 0.001 /Техникийн үзүүлэлтийг хавсаргав/	ком	1	2,648,000	2,648,000
17	Давхар ус нэрэгч багаж	БНСҮ	ISO 9001/ ISO 14001, 0.2 us Final Filter Up-to 1.5l/min /Техникийн үзүүлэлтийг хавсаргав/	ком	1	15,345,000	15,345,000
<b>НӨАТ-тэй үнэ</b>							<b>62,175,820</b>

Жич: Нийлүүлэх багажыг ажиллуулж хүлээлгэн өгөх ба баталгааг олгоно.

Амгалан дулааны станц ТӨХК -ний

Химийн инженер *Д.Индер* Д.Хишигшинэн

Грийн химийстри ХХК

Химич

*О.Ариунжаргал*

О.Ариунжаргал

Англи хэлнээс Монгол хэлрүү хөрвүүлэв.  
PC820 pH/Кондуктометрийн иж бүрдэл

Үзүүлэлт	Модел	PC820
pH	Электрод	LabSen 211 Дээд зэрэглэлийн pH электрод
	Хэмжих хүрээ	(-2.000 аас 19.999) pH
	Нягтаршил	0.1/0.01/0.001 pH
	Нарийвчлал	±0.002 pH ±1 цифр
	Оролтын гүйдэл	≤1x10 <sup>-12</sup> A
	Оролтын эсэргүүцэл	≥3x10 <sup>12</sup> Ω
	Тогтвортой байдал	±0.002 pH/3h ±1 цифр
	Тем. Нөхөн олговрын хүрээ	0 аас 100°C (32 to 212°F) Автомат эсвэл гар тохиуулга
mV	Хэмжих хүрээ	±1999.9 мВ
	Нягтаршил	0.1 мВ
	Нарийвчлал	±0.03% F.S ±1 цифр
Дамжуулалт	Электрод	2401-C Шилэн дамжуулалтын электрод
	Хэмжих хүрээ	Дамжуулах чадвар: 0-ээс 2000 мС/см хүртэл, үүнд: (0.00~19.99) мкС/см (20.0~199.9) мкС/см (200~1999) мкС/см (2.00~19.99) мС/см (20.0~199.9) мС/см (200~1999) мС/см
		TDS: (0-ээс 100) г/л
		Давсжилт: (0-100) ppt
		Эсэргүүцэл: (0-ээс 100) MΩ?cm
	Шийдвэр	0.01/0.1/1 мкС/см 0.01/0.1/1 мС/см
	Нарийвчлал	±0.5% F.S ±1 цифр
	Тем. Нөхөн олговрын хүрээ	0 to 50°C (32 to 122°F) Автомат эсвэл гарын авлагатай
	Электродын тогтмол	0.01/0.1/1/10 cm <sup>-1</sup>
Температур	Электрод	MP500 температурын электрод
	Хэмжих хүрээ	-10-110°C (14-230°F)
	Нягтаршил	0.1°C
	Нарийвчлал	±0.4°C ±1 цифр
Бусад	Хадгалах багтаамж	1000 бүлэг
	Хадгалах контент	Дугаарлалт, огноо, цаг, Хэмжилт, нэгж, температур
	Өгөгдлийн гаралт	USB
	Эрчим хүчиний хангамж	Оролт: 120V AC 60Hz; Гаралт: DC9V/300mA, 2.7VA
	IP үнэлгээ	Ус чийгнээс хамгаалах, тоос үл нэвтрэх IP54 хамгаалалттай
	Хэмжээ ба жин	(**) инч / фунт хайрцаг: (10*10 <sup>7</sup> ) инч / 7.5 фунт.

Анчимаа" ХХК-ийн орчуулгын төвд орчуулж баталгаажуулав.

Орчуулагч: /гарын үсэг/  
TRANSLATION BUREAU

Хаяг: УБ хотын Баянзүрх дүүргийн 5-р хороо Энхтууд төв 210 тоот

